



БАРИЛГЫН ЗАХИАЛАГЧ,
ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУДАД

ДУНГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
УЛСЫН (АХЛАХ) БАЙЦААГЧИЙН
ЗӨВЛӨМЖ

2025.06.09 № 02-22-01/072/08

Барилгын угсралтын ажлын чанар,
технологийн аюулгүй байдлыг
хангуулах тухай

Барилгын угсралтын ажил гүйцэтгэх явцад хууль тогтоомжийг зөрчих, төлөвлөлт, техникийн шийдлийн алдаа гаргах, барилгын бат бэх тогтвортой байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйн улмаас байгаль орчин, хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх, нийтийн болон гуравдагч этгээдийн эрх ашиг сонирхлыг зөрчих зэрэг нийтлэг дутагдлууд давтагдаж байгаа нь барилга байгууламжийн ашиглалтын үеийн техникийн аюулгүй байдал хангагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд дээрх асуудлуудад онцгой анхаарч, эрсдэлээс урьдчилан сэргийлэн угсралтын ажлын чанар, болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллахыг **ЗӨВЛӨЖ** байна. Үүнд:

1. Барилгын угсралтын ажил гүйцэтгэгч байгууллага, аж ахуйн нэгжүүд нь эрх бүхий байгууллагаар батлагдаж, магадлалаар хянагдсан ажлын зураг төсөл болон эрх бүхий байгууллагаас олгосон барилгын угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн хүрээнд барилгын ажлын зөвшөөрөл авсны дараа барилгын угсралтын ажлыг эхлэх;

2. Барилгад зураг төслийн болон стандартын шаардлага бүрэн хангасан барилгын материал хэрэглэж стандарт тогтоогдоогүй бүтээгдэхүүн материалуудыг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ туршилтад тогтмол хамруулж үе шатны далдлагдсан ажлын чанарыг баталгаажуулах;

3. Барилгын угсралтын ажилд бетон зуурмагийг цутгах ажилд "Цутгамал төмөр бетон бүтээцийн ажил гүйцэтгэх заавар" БД 52-102-04 болон "Цутгамал бетон, төмөр бетон бүтээц" БНБД 52-02-05-ын дагуу бетон зуурмагийн конусан суултыг заавал тодорхойлж, цутгасан хийц бүтээц бүрийн бетон зуурмагаас дээж авч, бетоны шахалтын бат бэхийг хангуулж байх, цутгалтын дараах бетоны арчилгааг шаардлагын дагуу гүйцэтгэх;

4. Цемент, тоосго, хийт бетон гулдмай, дулаан тусгаарлах болон ханын өрлөгт хэрэглэх материалууд стандарт, зураг төслийн шаардлага бүрэн хангасан тохирлын гэрчилгээтэй байх;

5. Тохирлын гэрчилгээгээр баталгаажуулагдсан барилгын материалуудын анги, төрөл, маркийн үзүүлэлтүүдийг нягтлан, шаардлага хангасан бүтээгдэхүүнийг сонгон хэрэглэж байх;

6. Арматур нь барилгын зураг төсөлд заасан анги, төрөл, маркийн шаардлага хангасан, тохирлыг гэрчилгээ, сертификаттай байх, барилгын даацын бүтээцэд хэрэглэх арматур MNS JISG 3112-2002 стандартын SD390 **дөрлийн** ОХУ-д

үйлдвэрлэгдсэн А-400 /А-III/ ангилалын, БНХАУ-д үйлдвэрлэгдсэн HRB 400 ангилалын шаардлага хангасан байх;

7. Цонх, хаалга нь дулаан техникийн үзүүлэлт, зураг төслийн шаардлага хангасан байх, цонх, хаалганы хуванцар хүрээ 5-аас дээш тасалгаатай, шилэн багцны шил хоорондын зай 16 мм-ээс дээш үзүүлэлт бүхий цонх, хаалгыг хэрэглэж байх;

8. Инженерийн шугам сүлжээний сүлжээний угсралт, засвар, шинэчлэлтийн ажилд ажилд хэрэглэсэн барилгын материал бүтээц эдлэхүүн, тоног төхөөрөмж нь хууль, дүрэм, стандарт, зураг төслийн шаардлагыг хангасан байх;

9. Барилга угсралтын ажилд "Захиалагчийн дүрэм", "Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх дүрэм"-ийн дагуу зураг төсөл зохиогчийн хөндлөнгийн хяналт шалгалтыг тогтмолжуулж, эдгээр шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгаж хэвших;

10. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцүүлэн өөрийн компанийн "Дотоод хяналтын журам"-ыг боловсруулан баталж, мэргэжлийн боловсон хүчин бүхий тус хяналтын нэгжийг зохион байгуулах ажиллуулж, ажлын байрны онцлогт нийцсэн аюулгүй ажиллагааны дүрэм, заавар, журам баталж, мөрдөн ажиллах;

11. Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл боловсруулан мөрдөж хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах;

12. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулахад барилгын талбай, нэгж хэсэг дээр инженер, техникийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэн тэдгээрийг томилон ажиллуулах;

13. Өргөх, зөөх, тээвэрлэх машин механизмын аюулгүй байдал, техникийн бичиг баримтанд оношилгоо, үзлэгт орсон тэмдэглэгээг бүрэн даруулсан байх,

14. Өргөх байгууламжийг ашиглах үед мэргэжлийн байгууллагаар угсралт, засвар үйлчилгээг хийлгэх, мэргэжлийн үнэмлэхтэй ажилчдыг томилж ажиллуулах, өргөх байгууламжийн техникийн магадлалыг хийлгэх, эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр ашиглах;

15. Барилга угсралтын ажлын байрны орчны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, 1.5 метрээс дээших өндөрт ажиллаж байгаа ажилчдад өндрийн бүс хэрэглүүлж хэвших, өндрийн хаалт хамгаалалт, хашлага, тор татах ажлыг хийж аюулгүй байдлыг хангаж ажиллах.

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Э.ЦЭРЭННАДМИД